ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Дипломат төлөөлөгчийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: САГ-2026/6/НА-СТА-ТТЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | Санхүүгийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас:261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Э.Энхбаатар<br>Утас: 260512 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn<br>Ахлах аудитор: П.Батцэцэг<br>Утас: 261628 Цахим хаяг: battsetsegp@audit.gov.mn<br>Аудитор: С.Алтанхуяг<br>Утас: 261628 Цахим хаяг: altankhuyags@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан ..... 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан ..... 5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан/ ..... 6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 7
2.6 Аудит хийсэн-нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..... 9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ..... 9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..... 10
3.4.1 Мөнгөн хөрөнгө ..... 10
3.4.2 Авлага ..... 11
3.4.3 Урьдчилгаа ..... 11
3.4.4 Бараа материал ..... 11
3.4.5 Үндсэн хөрөнгө ..... 12
3.4.6 Өр төлбөр ..... 12
3.4.6 Засгийн газрын хувь оролцоо ..... 13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 13
3.5.1 Төсвийн төлөвлөлт ..... 13
3.5.2 Төсвийн гүйцэтгэл ..... 14
3.5.3 Нэмэлт төсөв ..... 15
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл ..... 15
4. АУДИТЫН ТАЙЛАН ..... 16
4.1 Ерөнхий зүйл ..... 16
4.2 Материаллаг байдал ..... 16
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 16
4.3.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ..... 16
4.3.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 16
4.4 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 17
4.4.1 Завсрын аудитын талаар ..... 17
4.4.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн ..... 17
4.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 18
5.1 Албан шаардлага ..... 18
5.2 Зөвлөмж ..... 19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ..... 21

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БТГ | Байнгын төлөөлөгчийн газар |
| ДТГ | Дипломат төлөөлөгчийн газар |
| ЗГХЭГ | Засгийн газрын хэрэг эрхлэх газар |
| ЗХЖШ | Зэвсэгт хүчний жанжин штаб |
| СТОУС | Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ҮАГ | Үндэсний аудитын газар |
| ЭСЯ | Элчин сайдын яам |

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.25 № 792

танай ____________-ны №____________-т

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Л.МӨНХТҮШИГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-Т заасны дагуу Дипломат төлөөлөгчийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дипломат төлөөлөгчийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд Аргентин улсын Буэнос-Айрес, Испани улсын Мадрид хотуудад Элчин сайдын яам, Шотланд улсын Эдинбург, Герман улсын Франкфурт хотуудад Консулын газар шинээр нээхээр 7,952.5 сая төгрөг батлагдсан боловч Засгийн газрын шийдвэр гараагүйн улмаас тус төсөв зарцуулагдаагүй байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 769, 307 дугаар тогтоолуудаар 13 Дипломат төлөөлөгчийн газрын 2,805.7 сая төгрөгийн 15 авто тээврийн хэрэгсэл, 2025 оны 768, 306 дугаар тогтоолуудаар 34 Дипломат төлөөлөгчийн газрын 2,398.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хөрөнгө акталж данснаас хассан байна.

Дипломат төлөөлөгчийн газрын 2025 оны төсвийн жилд зарцуулах зардлыг 182,883.8 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 144,903.5 сая төгрөг буюу 79.2 хувьтай байгаа нь Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулиар Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт бүрэн биелэхгүй байх нөхцөл бүрдсэн байна.

**Бусад асуудал**

Дипломат төлөөлөгчийн газар нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж хүргүүлсэн.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

Б.МАГНАЙСҮРЭН

Z:\Yawsan_Bichig\2026\0325 SAG-19.Docx

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */мянган төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **11,991,531.7** | **14,197,563.2** |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 3,513,045.0 | 2,264,247.5 |
| 33 | АВЛАГА | 3,513,910.4 | 6,622,717.0 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 260,125.8 | 333,899.1 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 4,704,450.4 | 4,976,699.6 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **463,979,920.3** | **459,517,234.2** |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 463,979,920.3 | 459,517,234.2 |
| 39100 | Газар | 46,095,332.2 | 46,095,332.2 |
| 39200 | Биет хөрөнгө | 386,676,609.2 | 382,209,948.4 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 31,207,978.9 | 31,211,953.6 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2** | **475,971,452.0** | **473,714,797.4** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **2,895,113.1** | **913,175.5** |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 2,895,113.1 | 913,175.5 |
| 41300 | Өглөг | 2,895,113.1 | 913,175.5 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **473,076,338.9** | **472,801,621.9** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 473,076,338.9 | 472,801,621.9 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 189,945,563.1 | 189,945,563.1 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | (122,769,374.9) | (123,228,641.1) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 251,200,863.6 | 251,200,863.6 |
| 51400 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 154,699,287.1 | 154,883,836.3 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5** | **475,971,452.0** | **473,714,797.4** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **179,339,476.9** | **194,246,418.6** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 12,170,596.7 | 194,246,418.6 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 167,168,880.2 | - |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **185,545,708.7** | **196,265,683.0** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 176,721,177.0 | 196,265,683.0 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 131,897,726.2 | 157,876,373.1 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 51,130,609.2 | 62,364,841.2 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,826,744.1 | 2,156,434.2 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 25,320,386.8 | 32,394,207.5 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 3,059,433.6 | 3,665,722.2 |
| 2105 | Нормативт зардал | 15,099.1 | 23,268.4 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,737,278.0 | 3,407,348.4 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 8,035,277.2 | 12,566,794.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 17,960,627.1 | 19,432,844.5 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,812,271.2 | 21,864,912.6 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 44,823,450.7 | 38,389,309.9 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 8,824,531.7 | - |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **(6,206,231.8)** | **(2,019,264.4)** |
| **IV** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | **502,286.9** | **2,136,519.7** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **599,701.9** | **576,521.5** |
| **VII** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)** | **(97,415.0)** | **1,559,998.2** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)** | **(6,303,646.9)** | **(459,266.2)** |

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **178,562,620.7** | **184,488,443.3** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 11,393,740.5 | 184,488,443.3 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 167,168,880.2 | - |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **164,663,791.8** | **181,865,458.9** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **164,663,791.8** | **181,865,458.9** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **112,885,832.5** | **140,366,972.6** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 50,228,187.4 | 62,630,319.9 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 25,642,683.8 | 32,747,640.8 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 3,016,869.7 | 3,724,861.8 |
| 2105 | Нормативт зардал | 29,529.8 | 29,032.6 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,694,623.3 | 5,355,109.3 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 8,075,332.8 | 12,584,271.6 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 18,500,634.3 | 19,806,918.9 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,982,730.6 | 1,516,272.5 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **51,777,959.3** | **41,498,486.3** |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **13,898,829.0** | **2,622,984.4** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | **11,220,314.5** | **2,628,129.5** |
| **22** | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 11,220,314.5 | 2,628,129.5 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 11,220,314.5 | 2,628,129.5 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | (11,220,314.5) | (2,628,129.5) |
| **25** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ** | 187,258.9 | 1,243,652.5 |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | (78,767.0) | (1,243,652.5) |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | 2,599,747.4 | (1,248,797.6) |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 913,297.7 | 3,513,045.0 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 3,513,045.0 | 2,264,247.5 |

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан/

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|---|
| **1** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **470,572,853.4** | | **470,572,853.4** |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 470,572,853.4 | | 470,572,853.4 |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 8,807,132.3 | | 8,807,132.3 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | (6,303,646.9) | | (6,303,646.9) |
| **10** | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **473,076,338.8** | | **473,076,338.8** |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 473,076,338.8 | | 473,076,338.8 |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | 184,549.2 | | 184,549.2 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | (459,266.2) | | (459,266.2) |
| **20** | **2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **472,801,621.8** | | **472,801,621.8** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон / төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **НИЙТТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **182,883,751,500.00** | **168,468,749,325.97** | **(14,415,002,174.03)** | **92.1** |
| Татварын бус орлого | 182,883,751,500.00 | 168,468,749,325.97 | (14,415,002,174.03) | 92.1 |
| Нийтлэг татварын бус орлого | 3,000,000,000.00 | 11,181,535,127.73 | 8,181,535,127.73 | 372.7 |
| Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 3,000,000,000.00 | 6,111,072,553.30 | 3,111,072,553.30 | 203.7 |
| Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | - | 5,070,462,574.43 | 5,070,462,574.43 | |
| **Тусламжийн орлого** | **179,883,751,500.00** | **157,287,214,198.24** | **(22,596,537,301.76)** | **87.4** |
| Төсвөөс санхүүжих | 179,883,751,500.00 | 157,287,214,198.24 | (22,596,537,301.76) | 87.4 |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **182,883,751,500.00** | **144,903,472,284.79** | **(37,980,279,215.21)** | **79.2** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **182,883,751,500.00** | **144,903,472,284.79** | **(37,980,279,215.21)** | **79.2** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **169,566,088,900.00** | **138,496,879,238.22** | **(31,069,209,661.78)** | **81.7** |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 69,882,656,500.00 | 60,966,005,162.89 | (8,916,651,337.11) | 87.2 |
| Үндсэн цалин | 68,613,772,500.00 | 59,810,614,623.80 | (8,803,157,876.20) | 87.2 |
| Нэмэгдэл | 1,268,884,000.00 | 1,155,390,539.09 | (113,493,460.91) | 91.1 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,956,669,900.00 | 1,956,669,900.00 | - | 100.0 |
| Тэтгэврийн даатгал | 1,956,669,900.00 | 1,956,669,900.00 | - | 100.0 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **35,543,231,800.00** | **31,764,642,173.99** | **(3,778,589,626.01)** | **89.4** |
| Гэрэл, цахилгаан | 2,425,975,100.00 | 1,588,146,901.89 | (837,828,198.11) | 65.5 |
| Түлш, халаалт | 2,609,583,000.00 | 1,887,336,008.27 | (722,246,991.73) | 72.3 |
| Цэвэр, бохир ус | 1,029,484,600.00 | 959,988,318.52 | (69,496,281.48) | 93.2 |
| Байрны түрээс | 29,478,189,100.00 | 27,329,170,945.31 | (2,149,018,154.69) | 92.7 |
| **Хангамж, бараа материалын зардал** | **5,464,066,400.00** | **3,718,574,132.31** | **(1,745,492,267.69)** | **68.1** |
| Бичиг хэрэг | 454,230,600.00 | 407,564,643.05 | (46,665,956.95) | 89.7 |
| Тээвэр, шатахуун | 2,194,819,900.00 | 1,562,364,494.04 | (632,455,405.96) | 71.2 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,534,223,800.00 | 1,009,918,474.75 | (524,305,325.25) | 65.8 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 181,315,100.00 | 132,970,413.71 | (48,344,686.29) | 73.3 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,099,477,000.00 | 605,756,106.76 | (493,720,893.24) | 55.1 |
| **Нормативт зардал** | **60,166,700.00** | **29,073,622.34** | **(31,093,077.66)** | **48.3** |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 60,166,700.00 | 29,073,622.34 | (31,093,077.66) | 48.3 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | **10,620,632,100.00** | **7,438,489,522.94** | **(3,182,142,577.06)** | **70.0** |
| Багаж, техник, хэрэгсэл | 5,892,143,400.00 | 2,937,187,232.63 | (2,954,956,167.37) | 49.8 |
| Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 47,679,400.00 | - | (47,679,400.00) | - |
| Урсгал засвар | 4,680,809,300.00 | 4,501,302,290.31 | (179,507,009.69) | 96.2 |
| **Томилолт, зочны зардал** | **18,718,128,300.00** | **12,439,158,815.66** | **(6,278,969,484.34)** | **66.5** |
| Гадаад албан томилолт | 12,233,202,100.00 | 7,105,704,184.27 | (5,127,497,915.73) | 58.1 |
| Зочин төлөөлөгч хүлээн авах | 6,484,926,200.00 | 5,333,454,631.39 | (1,151,471,568.61) | 82.2 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **26,819,942,000.00** | **19,780,605,423.78** | **(7,039,336,576.22)** | **73.8** |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,168,484,700.00 | 3,483,865,761.56 | (3,684,618,938.44) | 48.6 |
| Даатгалын үйлчилгээ | 18,872,156,700.00 | 15,882,890,347.33 | (2,989,266,352.67) | 84.2 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 189,121,000.00 | 105,559,982.52 | (83,561,017.48) | 55.8 |
| Газрын төлбөр | 44,288,900.00 | 24,399,037.30 | (19,889,862.70) | 55.1 |
| Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 545,890,700.00 | 283,890,295.07 | (262,000,404.93) | 52.0 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **500,595,200.00** | **403,660,484.31** | **(96,934,715.69)** | **80.6** |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 500,595,200.00 | 403,660,484.31 | (96,934,715.69) | 80.6 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **13,317,662,600.00** | **6,406,593,046.57** | **(6,911,069,553.43)** | **48.1** |
| Бусад урсгал шилжүүлэг | 13,317,662,600.00 | 6,406,593,046.57 | (6,911,069,553.43) | 48.1 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 12,121,952,000.00 | 6,286,501,126.57 | (5,835,450,873.43) | 51.9 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 1,119,959,300.00 | 104,383,920.00 | (1,015,575,380.00) | 9.3 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 75,751,300.00 | 15,708,000.00 | (60,043,300.00) | 20.7 |
| ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | - | 23,565,277,041.18 | 23,565,277,041.18 | |
| АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | - | (23,565,277,041.18) | (23,565,277,041.18) | |
| Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | - | (23,565,277,041.18) | (23,565,277,041.18) | |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **3,513,045,048.04** | **3,513,045,048.04** | |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **2,264,247,469.02** | **2,264,247,469.02** | |
| **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **51** | **51** | - | 100.0 |
| Төсвийн байгууллага | 51 | 51 | - | 100.0 |
| **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **559** | **402** | (157) | 71.9 |
| Удирдах ажилтан | 56 | 49 | (7) | 87.5 |
| Гүйцэтгэх ажилтан | 294 | 285 | (9) | 96.9 |
| Үйлчлэх ажилтан | 209 | 68 | (141) | 32.5 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | | **4,502,222,914.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | **4,502,222,914.00** |
| 122 | Тусламжийн орлого | | 4,502,222,914.00 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | | 4,502,222,914.00 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 4,502,222,914.00 |
| 350015 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 4,502,222,914.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **4,502,222,914.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **4,502,222,914.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **4,498,222,914.00** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 1,664,314,694.00 |
| 210101 | Үндсэн цалин | | 1,664,314,694.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | **15,875,415.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 15,875,415.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | **982,998,628.34** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 12,000,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 6,000,000.00 |
| 210304 | Байрны түрээс | | 964,998,628.34 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | **36,000,000.00** |
| 210401 | Бичиг хэрэг | | 12,000,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 17,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 7,000,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | **262,016,585.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 84,456,585.00 |
| 210604 | Урсгал засвар | | 177,560,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | **170,374,316.00** |
| 210701 | Гадаад албан томилолт | | 150,374,316.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | 20,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | **249,226,954.34** |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | | 246,346,954.34 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | 2,880,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | **1,117,416,321.32** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 820,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 297,416,321.32 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **4,000,000.00** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 4,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 4,000,000.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Засгийн газрын 2016 оны 81 дүгээр тогтоолоор Гадаад харилцааны яамны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах таатай гадаад орчныг бүрдүүлэх;
- Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар Монгол Улсын хөгжлийн таатай гадаад орчныг бүрдүүлэх;
- Гадаад сурталчилгаа, соёлын харилцааг хөгжүүлэх, хилийн чанад дахь монгол иргэд, сургууль, цэцэрлэг, холбоо, нийгэмлэгийн үйл ажиллагаанд бодит дэмжлэг үзүүлэх.

Дипломат төлөөлөгчийн газрууд нь Монгол Улсын гадаад харилцааг Үндэсний аюулгүй байдлын болон Гадаад бодлогын үзэл баримтлалд тодорхойлсон зарчим, чиглэлийг улс орны болон дэлхий дахины шинэ нөхцөл байдалтай уялдуулан тууштай хэрэгжүүлж, хоёр ба олон талын харилцааны асуудлаар хэлэлцээ хийх, гэрээ хэлцэл байгуулах, тохиролцсон арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх, Монгол Улсын хөгжлийн зорилтыг шийдвэрлэхэд шаардагдах судалгаа хийх, холбогдох байгууллагад танилцуулах, хилийн чанадад Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн дагуу дипломат аргаар хамгаалах, гадаадад суугаа Монгол Улсын иргэдэд консулын болон нотариатын үйлчилгээ үзүүлэх, иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийг хөтлөх үйл ажиллагаа явуулдаг, Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Дээрх чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37-д "төсвийн төвлөрүүлэн захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг’’ гэж заасны дагуу Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Дипломат төлөөлөгчийн газар нь үйл ажиллагаандаа Дипломат албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Олон улсын гэрээний тухай хууль, Дипломат харилцааны тухай Венийн конвенц, Консулын харилцааны тухай Венийн конвенц, Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд Дипломат төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.Үүнд:

- Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль;
- Монгол улсын 2025 оны төсвийн тухай хууль;
- Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Засгийн газрын 2025 оны 125 дугаар “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” тогтоол;
- Засгийн газрын 2025 оны 122 дугаар “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” тогтоол;
- Засгийн газрын 2025 оны "Журам батлах тухай" 43 дугаар тогтоол /Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам/;
- Сангийн сайдын 2025 оны “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” шинэчлэн батлах тухай А/3 дугаар тушаал;

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй гэж үнэллээ.

Тайлант онд яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас төлөвлөгөөний дагуу Астана, Софи, Ханой, Бээжин, Прага, Вена, Оттава хотууд дахь дипломат төлөөлөгчийн газруудын үйл ажиллагаанд дотоод аудитыг гүйцэтгэсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дипломат төлөөлөгчийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаандаа мөрдөх 2022 онд шинэчлэн боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дипломат төлөөлөгчийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүү байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,256.6 сая төгрөгөөр буюу 0.5 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт* */мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **А** | **1** | **2** | **3=2-1** |
| Мөнгөн хөрөнгө | 3,513,045.0 | 2,264,247.5 | (1,248,797.6) |
| Авлага | 3,513,910.4 | 6,622,717.0 | 3,108,806.6 |
| Урьдчилгаа | 260,125.8 | 333,899.1 | 73,773.3 |
| Бараа материал | 4,704,450.4 | 4,976,699.6 | 272,249.2 |
| Үндсэн хөрөнгө | 463,979,920.3 | 459,517,234.2 | (4,462,686.2) |
| **Нийт хөрөнгийн дүн** | **475,971,452.0** | **473,714,797.4** | **(2,256,654.6)** |
| Нийт өр төлбөр | 2,895,113.1 | 913,175.5 | (1,981,937.6) |
| Цэвэр өмчийн дүн | 473,076,338.9 | 472,801,621.9 | (274,717.0) |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **475,971,452.0** | **473,714,797.4** | **(2,256,654.6)** |

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данстууд байна.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 2,264.3 сая төгрөг болж, өмнөх оноос 1,248.8 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл* */сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Кассад байгаа бэлэн мөнгө** | **144,669.1** | **403,126.2** | **258,457.2** |
| Гадаад валют | 144,669.1 | 403,126.2 | 258,457.2 |
| **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **3,368,376.0** | **1,861,121.2** | **(1,507,254.8)** |
| Гадаад валют | 3,368,376.0 | 1,861,121.2 | (1,507,254.8) |

| Дүн | 3,513,045.0 | 2,264,247.4 | (1,248,797.6) |
|---|---|---|---|

*Эх сурвалж: Дипломат төлөөлөгчийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 1,248.8 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны жилийн эцэст ЗГХЭГ-аас Женев дэх БТГ-ын дансанд “Дэлхийн эдийн засгийн чуулга” уулзалтад оролцохтой холбоотой зардал болох 2,575.8 сая төгрөг байршиж байсныг 2025 оны 1 дүгээр сард шилжүүлсэнтэй холбоотой байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд Батлан хамгаалах яамны ЗХЖШ-ын 2 албан хаагчийн цалин болон бусад зардалтай холбоотой 299.6 сая төгрөг, Боловсролын яамнаас Прага дахь элчин сайдын яаманд шилжүүлсэн “Монгол хэлний төв” байгуулах санхүүжилт болох 101.7 сая төгрөг, 50 ДТГ-ын төсвийн хэмнэлт, орлогын төвлөрүүлээгүй үлдэгдэл зэрэг байршиж байна.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 6,622.7 сая төгрөг болж, өмнөх оноос 3,108.8 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл* */мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Ажиллагчидтай холбогдсон авлага** | **14,665.0** | **27,069.2** | **12,404.2** |
| **Татаас, санхүүжилтийн авлага** | **-** | **3,111,072.6** | **3,111,072.6** |
| **Бусад авлага** | **3,499,245.4** | **3,484,575.2** | **(14,670.2)** |
| Байгууллагаас авах авлага | 2,863,619.1 | 2,831,742.9 | (31,876.2) |
| Хувь хүмүүсээс авах авлага | 635,626.3 | 652,832.4 | 17,206.1 |
| **Дүн** | **3,513,910.4** | **6,622,717.0** | **3,108,806.6** |

*Эх сурвалж: Дипломат төлөөлөгчийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлагын үлдэгдэл өмнөх оноос 3,108.8 сая төгрөгөөр өссөн нь ДТГ-уудын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөнөөс давж биелсэн 3,111.1 сая төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар тусгаж тайлагнасантай холбоотой байна.

Авлагын дансны 6,622.7 сая төгрөгийн үлдэгдлийн дийлэнх хэсгийг 3,111.1 сая төгрөгийн татаас санхүүжилтийн авлага, 27.1 сая төгрөг нь ажиллагчидтай холбоотой авлага, ДТГ-уудын ажилчдын байрны барьцаатай холбоотой авлага эзэлж байна.

### 3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 333.9 сая төгрөг болж, өмнөх оноос 73.8 сая төгрөгөөр өссөн байна

*Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл* */мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Урьдчилж гарсан зардал** | **260,125.8** | **126,622.0** | **(133,503.8)** |
| **Урьдчилгаа тооцоо** | **-** | **207,277.1** | **207,277.1** |
| Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа | - | 207,277.1 | 207,277.1 |
| **Дүн** | **260,125.8** | **333,899.1** | **73,773.3** |

*Эх сурвалж: Дипломат төлөөлөгчийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Урьдчилгаа дансны үлдэгдэл нэмэгдсэн нь Софи дахь Элчин сайдын яаманд авто тээврийн хэрэгсэл худалдан авахаар төлсөн 169.6 сая төгрөгийн урьдчилгаа төлбөр болон Канберра дахь ЭСЯ-ны автомашины түрээсийн 37.7 сая төгрөгийн урьдчилгаа төлбөртэй холбоотой байна.

### 3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 4,976.7 сая төгрөг болж, өмнөх оноос 272.2 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл* */мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Түүхий эд материал** | **629,958.6** | **592,067.3** | **(37,891.3)** |
| Тусгай зориулалттай материал | 629,958.6 | 592,067.3 | (37,891.3) |
| **Бэлэн бүтээгдэхүүн** | **3,916.2** | **48,721.2** | **44,805.0** |
| **Хангамжийн материал** | **4,070,575.6** | **4,335,911.2** | **265,335.5** |
| Бичиг хэргийн материал | 107,342.5 | 118,578.5 | 11,236.0 |
| Аж ахуйн материал | 527,237.4 | 598,909.2 | 71,671.8 |
| Сэлбэг хэрэгсэл | 140,868.8 | 149,485.8 | 8,617.0 |
| Түлш, шатах тослох материал | 46,556.9 | 71,757.0 | 25,200.1 |
| Хүнсний материал | 611,260.0 | 610,028.5 | (1,231.5) |
| Бусад хангамжийн материал | 2,637,310.1 | 2,787,152.1 | 149,842.0 |
| **Дүн** | **4,704,450.4** | **4,976,699.6** | **272,249.2** |

*Эх сурвалж: Дипломат төлөөлөгчийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материалын үлдэгдэл нэмэгдсэн нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 4,121.4 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 31.7 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, 3,732.9 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 162.0 сая төгрөгийн хөрөнгө акталж тайлагнасантай холбоотой байна.

### 3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 610,695.6 сая төгрөг болж, өмнөх оноос 10,578.5 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл* */мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Газар | 46,095,332.2 | 46,095,332.2 | - |
| **Биет хөрөнгө** | **522,754,066.5** | **533,327,395.6** | **10,573,329.2** |
| Барилга, байгууламж, орон сууц | 479,859,189.6 | 491,276,240.2 | 11,417,050.6 |
| Авто-тээврийн хэрэгсэл | 23,641,767.8 | 22,839,398.3 | (802,369.5) |
| Машин тоног төхөөрөмж (компьютер) | 8,393,740.0 | 8,436,341.3 | 42,601.3 |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 9,896,770.7 | 9,824,638.3 | (72,132.4) |
| Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 231,692.1 | 233,643.9 | 1,951.8 |
| Бусад үндсэн хөрөнгө | 656,917.2 | 626,031.9 | (30,885.3) |
| Ном | 73,989.1 | 91,101.7 | 17,112.6 |
| **Биет бус хөрөнгө** | **31,267,699.2** | **31,272,914.2** | **5,215.0** |
| Програм хангамж | 80,972.9 | 86,187.9 | 5,215.0 |
| Бусад биет бус хөрөнгө | 31,186,726.3 | 31,186,726.3 | - |
| **Дүн** | **600,117,097.9** | **610,695,642.1** | **10,578,544.2** |

*Эх сурвалж: Дипломат төлөөлөгчийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 610,695.6 сая төгрөг болж өсөхөд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Нью-Йорк, Берлин, Сөүл, Бээжин, Улаан-үд дэх ДТГ-ууд 6,989.9 сая төгрөгийн их засвар, гэнэтийн нөхцөл байдал үүссэний улмаас Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу урсгалаас Сөүл, Москва, Хөх хот дахь ДТГ-ууд 1,751.2 сая төгрөгийн их засвар хийж барилга байгууламжийг нэмж капиталжуулсан, улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр Варшав, Эль-Кувейт, Стокхольм, Сингапурын ДТГ-уудад 1,188.1 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэл худалдан авсан нь голлон нөлөөлжээ.

Тайлант онд ТӨБЗГ-ын 769, 307 дугаар тогтоолуудаар 13 ДТГ-ын 15 автомашин, 1 чиргүүл, 1 мопед нийт 2,805.7 сая төгрөгийн автомашин тээврийн хэрэгсэл, ТӨБЗГ-ын 768, 306 дугаар тогтоолуудаар 34 ДТГ-ын 2,398.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хөрөнгө акталж дансаас хассан байна.

### 3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 913.2 сая төгрөг болж, өмнөх оноос 1,981.9 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Өглөг** | **15,237.9** | **7,281.0** | **(7,956.9)** |
| Ажилчидтай холбогдсон өглөг | 15,237.9 | 7,281.0 | (7,956.9) |
| **Бусад өглөг** | **2,879,875.3** | **905,894.5** | **(1,973,980.8)** |
| Байгууллагад төлөх өглөг | 2,787,381.8 | 890,450.7 | (1,896,931.1) |
| Хувь хүмүүст төлөх өглөг | 92,493.5 | 15,443.8 | (77,049.7) |
| **Дүн** | **2,895,113.1** | **913,175.5** | **(1,981,937.7)** |

*Эх сурвалж: Дипломат төлөөлөгчийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Өглөгийн дансны үлдэгдэл буурахад Женев хот дахь БТГ-ын дансанд ЗГХЭГ-аас Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтад оролцохтой холбоотой зардал болох 2,575.8 сая төгрөгийг өглөгөөр бүртгэснийг холбогдох байгууллагад шилжүүлэн өглөгийг барагдуулсантай холбоотой байна.

### 3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 472,801.6 сая төгрөг болж, өмнөх оноос 274.7 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо* *\/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал | 189,945,563.1 | 189,945,563.1 | - |
| **Хуримтлагдсан үр дүн** | (122,769,374.9) | (123,228,641.1) | (459,266.2) |
| Өмнөх үеийн үр дүн | (116,465,728.0) | (122,769,374.9) | (6,303,646.9) |
| Тайлант үеийн үр дүн | (6,303,646.9) | (459,266.2) | 5,844,380.7 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 251,200,863.6 | 251,200,863.6 | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 154,699,287.1 | 154,883,836.3 | 184,549.2 |
| **Дүн** | **473,076,338.9** | **472,801,621.9** | **(274,717.0)** |

*Эх сурвалж: Дипломат төлөөлөгчийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өмнөх үеийн үр дүн болон хуримтлагдсан үр дүнгээс шалтгаалж 274.7 сая төгрөгөөр буурсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Дипломат төлөөлөгчийн газрын 2025 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 201,083.2 сая төгрөгөөр төлөвлөж, санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 199,683.2 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоос 1,400.0 сая төгрөгөөр бүрдүүлэхээр тооцож, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас бараа, ажил үйлчилгээний зардлыг 7,580.7 сая төгрөгөөр бууруулж, урсгал шилжүүлгийн зардлыг 1,348.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт төсвийг 6,232.5 сая төгрөгөөр бууруулж, 194,850.7 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор батлагдсан төсвийн бараа үйлчилгээний зардлыг 4,317.3 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 29.7 сая төгрөг, нийт 4,347.0 сая төгрөгөөр урсгал зардлыг бууруулж, 190,503.7 сая төгрөгөөр төсвийг тодотгосон байна.

Тайлант онд төсөвт дараах зохицуулалтуудыг хийсэн байна. Үүнд:

- Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн 03/3734 дүгээр албан бичгээр ДТГ-ын урсгал төсвийг 4,000.0 сая төгрөгөөр бууруулж, гадаад

харилцааны яамны байр ашиглалтын зардлыг 2,000.0 сая төгрөгөөр, багаж хэрэгслийн зардлыг 2,000.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн;
- Гадаад харилцааны сайдын 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 01/4937 дугаар албан бичгээр ДТГ-ын урсгал зардлыг 3,620.0 сая төгрөгөөр бууруулж, Гадаад харилцааны яамны гадаад албан томилолт зардлыг 320.0 сая төгрөгөөр, зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг 3,300.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн зохицуулалтуудыг хийсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 179,883.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 3,000.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоос бүрдүүлэхээр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр урсгал зардлыг санхүүжүүлэхээр 157,287.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 6,111.1 сая төгрөгийн үйл ажиллагааны нэмэлт орлогыг бүрдүүлсэн байна.

Нийт урсгал зардлын гүйцэтгэл 144,903.5 сая буюу 79.2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллааны зардлыг 27,384.6 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой зардлыг 3,107.7 сая төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэгийн зардлыг 1,075.6 сая төгрөг, сургалтын төлбөрийн буцалтгүй дэмжлэг арга хэмжээний зардлыг 5,835.5 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэлийг арга хэмжээгээр авч үзвэл, 6 арга хэмжээнээс 1 арга хэмжээ хэрэгжээгүй, 2 арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байгаа нь төсвийн төлөвлөгөөг үндэслэлгүй боловсруулж, баталсантай холбоотой гэж үзлээ.

*Хүснэгт 8. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл* */мянган төгрөг/*

| Код | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **70301** | **Гадаад улс орнууд дахь дипломат** | **182,883,751.5** | **144,903,472.3** | **37,980,279.2** | **79.2** |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 162,397,604.2 | 135,013,013.5 | 27,384,590.7 | 83.1 |
| 80103 | Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ | 43,280.0 | - | 43,280.0 | |
| 80218 | Улс орноо гадаадад сурталчлах | 2,588,652.9 | 2,055,025.9 | 533,627.0 | 79.4 |
| 80226 | Байр ашиглалтын үйлчилгээ | 4,536,551.8 | 1,428,839.8 | 3,107,712.0 | 31.5 |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг | 1,195,710.6 | 120,091.9 | 1,075,618.7 | 10.0 |
| 81820 | Сургалтын төлбөрийн буцалтгүй дэмжлэг | 12,121,952.0 | 6,286,501.1 | 5,835,450.9 | 51.9 |

Баталсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу хийх 2025-2026 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

- ДТГ-ын төвийн дансанд биет бус хөрөнгийн дансанд 64.6 сая төгрөгийн тайлан нэгтгэлийн Талст программ, хүний нөөцийн программ хангамж, санхүүгийн программ хангамжууд бүртгэлтэй байна.
- Тайлант онд цалингийн зардлыг 73,219.9 сая төгрөгөөр баталсан ба төсвийн тодотголоор 3,337.3 сая төгрөгөөр бууруулж 69,882.7 сая төгрөгөөр баталсан байна.
- Засгийн газрын 2019 оны 442 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Дипломат төлөөлөгчийн газруудын орон тооны хязгаар”-ыг Засгийн газрын 2025 оны 124 дугаар тогтоолоор нийт 421 орон тоотой байхаар өөрчлөн баталсан байна. Гүйцэтгэлээр удирдах 49, гүйцэтгэх 285, үйлчлэх 68 албан хаагч ажиллаж байна.
- Гадаад томилолтын зардалд 12,233.2 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 7,105.7 сая төгрөг, гадаад зочин төлөөлөгч хүлээн авах зардалд 6,484.9 сая төгрөгийн төсөв баталж, 5,333.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Нэмэлт санхүүжилтийн дансанд Тайпей дэх Улаанбаатар хотын Худалдааны төлөөлөгчийн газрын санхүүжилтэд 2,000.0 сая төгрөг, Москва дахь ЭСЯ-ны хөрөнгө оруулалтын засварын 800.0 сая төгрөг, Монгол-Зөвлөлтийн дайчдын хөшөөг засварлах зардалд 177.6 сая төгрөг, ДТГ-уудад ЗХЖШ-аас томилогдон ажиллах албан хаагчдын зардал 1,521.3 сая төгрөг, ССАЖЗЯ-наас шилжүүлсэн 1 албан хаагчийн томилолтын зардал 3.4 сая төрөг, нийт 4,502.2 сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр Тайпей дэх Улаанбаатар хотын Худалдааны төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны зардлын 2,000.0 сая төгрөг, Москва дахь ЭСЯ-ны хөрөнгө оруулалтын засварын 800.0 сая төгрөг, БНХАУ дахь Монгол-Зөвлөлтийн дайчдын хөшөөг засварлах зардлын 177.6 сая төгрөг, ДТГ-уудад ЗХЖШ-аас томилогдон ажиллах албан хаагчдын зардлын 1,521.3 сая төгрөг, ССАЖЗЯ-наас шилжүүлсэн 1 албан хаагчийн томилолтын зардлын 3.4 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Дипломат төлөөлөгчийн газрын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 8,378.7 сая төгрөгийн их засварын ажил, 1,190.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 6,989.9 сая төгрөгийн их засварын ажил хийж, 1,188.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дипломат төлөөлөгчийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн дипломат төлөөлөгчийн газар, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой ДТГ-ын төвийн дансны тайланг гаргаж аудитад хамруулах, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хуульд заасны дагуу зохион байгуулах, орлогыг бодитой төлөвлөхтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор П.Батцэцэг, аудитор С.Алтанхуяг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг, аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Дипломат төлөөлөгчийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 03/1006 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 185,545.7 сая төгрөгийн 1.0 хувиар тооцож, 1,855.5 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.3.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага болон дээд шатны төсвийн захирагчаас төрийн хэмнэлттэй холбоотой тушаал, шийдвэр гарах, арга хэмжээ авах нөхцөл байдал үүсээгүй, 2025 оны баталсан төсөвт багтаан үйл ажиллагаагаа явуулсан байна.

#### 4.3.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих нийт 171 мэдээллийг хугацаандаа байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн

холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.4 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.4.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитын хугацаанд ДТГ-ын 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, гадаад, дотоод орчин, хяналтын талаар ойлголт олж, аудитын урьдчилсан судалгааны болон төлөвлөлтийн үе шатны ажлуудыг гүйцэтгэж, төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулж батлуулсан.

#### 4.4.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 3,001.1 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 1,847.1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг өгснийг нотлох баримтад үндэслэн хэрэгжилтийг үнэлэхэд бүрэн хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 9 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт* */мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 3 | 3,001,109.3 | 3 | 3,001,109.3 | 100.0 |
| Зөвлөмж | 3 | 1,847,127.8 | 3 | 1,847,127.8 | 100.0 |
| **Дүн** | **6** | **4,848,237.1** | **6** | **4,848,237.1** | **100.0** |

### 4.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нийслэлийн Засаг даргын тамгын газраас Тайваны Тайбэй хот дахь худалдааны төлөөлөгчийн газрын санхүүжилт 2,000.0 сая төгрөгийг ДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан санхүүжилсэн асуудлуудыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 145.5 сая төгрөгийн 1 алдаа[1] илэрснийг аудитын явцад залрууллаа.

*Залруулсан алдаа:*

Монгол Улсаас Австралийн Холбооны Улсад суугаа элчин сайдын яамны ажилчдын 145.5 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг зардалд хааж бүртгээгүй алдаа нь "УСНББОУС 1" Санхүүгийн тайлангийн толилуулга, үнэн зөв, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Аудитаар нийт 480.3 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 233.0 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 247.4 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн залруулагдаагүй 480.3 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

<u>*Илрүүлэлт-1:*</u> Болгар Улсын Софи хотод суугаа элчин сайдын яам нь батлагдсан хөрөнгө оруулалтын төсөвт тусгагдаагүй, холбогдох газрын зөвшөөрөлгүйгээр авто тээврийн хэрэгсэл худалдан авахаар 169.6 сая төгрөгийн урьдчилгаа төлбөр төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; 42 дугаар зүйлийн 41.2.2-т батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 1.2-т "Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, акталж данснаас хасах, шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

<u>*Шийдвэрлэсэн нь:*</u> Батлагдсан төсөвт тусгагдаагүй хөрөнгө оруулалтын ажлыг санхүүжүүлдэг зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

<u>*Илрүүлэлт-2:*</u> ДТГ-т олон жилийн насжилттай болон тооцоо нийлээгүй дараах авлага бүртгэлтэй байна. Үүнд:

- Гадаадын иргэн, харьяатын газраас авах визийн наадаг хуудасны төлбөр болох 2021 онд үүссэн 39.9 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байгаа бөгөөд тооцоо нийлсэн актгүй;
- ДТГ-уудын ажилчдын ХХОАТ-ын төлөлтийг 2024 онд 14.7 сая төгрөгөөр илүү, 2025 онд 8.9 сая төгрөгөөр илүү төлж авлага үүсгэсэн боловч харьяа дүүргийн татварын албатай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

<u>*Шийдвэрлэсэн нь:*</u> Олон жилийн насжилттай авлагыг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

<u>*Илрүүлэлт-3:*</u> ДТГ-уудын санхүүгийн тайлангийн нэгтгэл хийхэд Аксплорер ХХК-ны Таст санхүүгийн программыг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд тус программ хангамж нь “Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамжийн жагсаалтад бүртгэлгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.11-д "Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн програм хангамжийг нийтэд мэдээлэх", Сангийн сайдын 2022 оны 09 сарын 30-ний өдрийн 197 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт "Аж ахуй нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага"-ын 1.2-т "Тооцооны аргачлал нь олон улсын стандартад заагдсан бүх аргыг хэрэглэх боломжтой байх", 1.10-т "Санхүүгийн тайлангийн аудит хийхэд хялбар дөхөмтэй, мэдээллийн эх үүсвэр иж бүрнээр/ анхан шатны баримтын мэдээлэл, дансанд бичилт хийсэн мэдээлэл/ тодорхой харуулдаг байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамж ашиглаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

**5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал***

*Илрүүлэлт:* Дипломат төлөөлөгчийн газрын төв нь 73.8 сая төгрөгийн батлагдсан төсөвтэй, 21.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 586.8 сая төгрөгийн бараа материалтай, Төрийн сангийн 100900016005 тоот данстай байна. Тус дансны санхүүгийн тайланг аудитад хамруулдаггүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4-р зүйл 4.1.37."төсвийн төвлөрүүлэн захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг; 8.9.1-д "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Дипломат төлөөлөгчийн газрын төвийн 100900016005 тоот дансны санхүүгийн тайланг ирүүлж аудитад хамруулах.

***2. Хөрөнгө оруулалтын төлөвлөлтэй холбоотой асуудал***

*Илрүүлэлт:* ГХС-ын хөрөнгө оруулалтын багцад тусгаагүй Москва хотод суугаа элчин сайдын яамны барилгын их засварын ажлын санхүүжилтийг Сангийн сайдын багцад 500,000.0 мянган төгрөгөөр батлуулсан бөгөөд нэмэлтээр ГХС-ын албан хүсэлтээр 300.0 сая төгрөг нэмж тусгуулан нийт 800.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг батлуулж ДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1-д "төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаг төсвийн шууд захирагч нь жилийн төсвийн төслөө жил бүрийн 7 дугаар сарын 09-ний дотор харьяалах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэх" 28.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулах төсөл, арга хэмжээний саналыг дараах журмаар боловсруулж, эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг хуульд заасан хугацаанд төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэн, Төсвийн ерөнхийлөн захирагч улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулж байх.

### ***3. Өр төлбөртэй холбоотой асуудал***

*__Илрүүлэлт__:* Бүгд найрамдах Хятад ард улсын Хонконг дахь Монгол Улсын элчин сайдын яаманд ЗХЖШ-аас дипломат төлөөлөгчөөр томилогдон ажиллах албан тушаалтны 2025 оны цалингийн болон зардлын санхүүжилт болох 247.4 сая төгрөгийг 08 дугаар сард шилжүүлсэн авсан, тус албан хаагчийн томилогдох хугацаа түр хойшилж, үүнтэй холбогдуулж тухайн санхүүжилтийг дараагийн жилд тусган санхүүжүүлэхээр өглөг үүсгэн тооцоо нийлж бүртгэсэн боловч татаас санхүүжилтийн авлагаар тусгахгүйгээр улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах гэж заасантай нийцэхгүй байна.

*__Өгсөн зөвлөмж:__* Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулж байх.

### ***4. Орлого төлөвлөлттэй холбоотой асуудал***

*__Илрүүлэлт__:* Үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг бодитой төлөвлөөгүйн улмаас орлого 3,111.1 сая төгрөгөөр давж биелэж, тус давсан орлогыг татаас санхүүжилтийн авлагаар тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.5-т “төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого”; Сангийн сайдын 2025 оны 240 дугаар тушаал 3.3-д “Энэ журмын 3.1.1-т заасан орлогын сүүлийн гурван жилийн гүйцэтгэл болон 3.1.2-т заасан орлогын үндсэн үйл ажиллагаанд хамаарч үргэлжлэх байдлыг тус тус харгалзан үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*__Өгсөн зөвлөмж:__* Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг төлөвлөхдөө орлогын сүүлийн гурван жилийн гүйцэтгэл болон орлогын үндсэн үйл ажиллагаанд хамаарч үргэлжлэх байдлыг тус тус харгалзан бодитой төлөвлөж байх.

Аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуульд заасан хугацаанд гарган ҮАГ-т ирүүлж, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Монгол Улсаас Австралийн Холбооны Улсад суугаа элчин сайдын яамны ажилчдын 145,461.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг зардалд хааж бүртгээгүй алдааг залруулсан. | 1 | 145,461.0 | | | 1 | 145,461.0 | 1 | 145,461.0 | | | | |
| **Дүн** | **1** | **145,461.0** | | | **1** | **145,461.0** | **1** | **145,461.0** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Болгар Улсын Софи Улсад суугаа элчин сайдын яам нь батлагдсан хөрөнгө оруулалтын төсөвт тусгагдаагүй, холбогдох газрын зөвшөөрөлгүйгээр авто машин худалдан авахаар 169,570.1 мянган төгрөгийн урьдчилгаа төлбөр төлсөн байна. | 1 | 169,570.1 | | | 1 | 169,570.1 | | | | | | |
| ДТГ-т олон жилийн насжилттай болон тооцоо нийлээгүй  дараах авлага бүртгэлтэй байна. Үүнд:<br>1. Гадаадын иргэн, харьяатын газраас авах визийн наадаг хуудасны төлбөр болох  2021 онд үүссэн 39,871.7 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байгаа бөгөөд тооцоо нийлсэн актгүй;<br>2.ДТГ-уудын ажилчдын ХХОАТ-ын төлөлтийг 2024 онд 14,665.0 мянган төгрөгөөр илүү, 2025 онд 8,857.5 мянган төгрөгөөр илүү төлж авлага | 1 | 63,394.1 | | | 1 | 63,394.1 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| үүсгэсэн боловч харьяа дүүргийн татварын албатай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна | | | | | | | | | | | | |
| ДТГ-уудын санхүүгийн тайлангийн нэгтгэл хийхэд Аксплорер ХХК-ны Таст санхүүгийн программыг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд тус программ хангамж нь “Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамжийн жагсаалтад бүртгэлгүй байна. | 1 | - | | | 1 | - | | | | | | |
| Дипломат төлөөлөгчийн газрын төв нь 73,757.9 мянган төгрөгийн батлагдсан төсөвтэй, 21,471.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 586,765.4 мянган төгрөгийн бараа материалтай, Төрийн сангийн 100900016005 тоот данстай байна. Тус дансны санхүүгийн тайланг аудитад хамруулдаггүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| ГХС-ын хөрөнгө оруулалтын багцад тусгагдаагүй Москва хотод суугаа элчин сайдын яамны барилгын их засварын ажлын санхүүжилтийг Сангийн сайдын багцад 500,000.0 мянган төгрөгөөр батлуулсан бөгөөд нэмэлтээр ГХС-ын албан хүсэлтээр 300,000.0 төгрөг нэмж тусгуулан нийт 800,000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг батлуулж ДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан олгож зарцуулсан байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Бүгд найрамдах Хятад ард улсын Хонконг дахь Монгол Улсын элчин сайдын яаманд ЗХЖШ-аас дипломат төлөөлөгчөөр томилогдон ажиллах албан тушаалтны 2025 оны цалингийн болон зардлын санхүүжилт болох 247,371.9 мянган төгрөгийг 08 дугаар сард шилжүүлсэн авсан, тус албан хаагчийн томилогдох хугацаа түр хойшилж, үүнтэй холбогдуулж тухайн санхүүжилтийг дараагийн жилд тусган санхүүжүүлэхээр өглөг үүсгэн тооцоо нийлж бүртгэсэн боловч татаас санхүүжилтийн авлагаар тусгахгүйгээр улсын төсөвт төвлөрүүлсэн байна. | 1 | 247,371.9 | | | | | 1 | 247,371.9 | | | | |
| Үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг бодитой төлөвлөөгүйн улмаас орлого 3,111.1 | 1 | - | | | | | 1 | - | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| сая төгрөгөөр давж биелэж, тус давсан орлогыг татаас санхүүжилтийн авлагаар тусгасан байна. | | | | | | | | | | | | |
| **Дүн** | **7** | **480,336.1** | | | **3** | **232,964.2** | **4** | **247,371.9** | | | | |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 25 өдөр Дугаар 1137/А0171076 Улаанбаатар хот

САГ-2026/6/НА-СТА-ТТ3

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дипломат төлөөлөгчийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Болгар Улсын Софи хотод суугаа элчин сайдын яам нь батлагдсан хөрөнгө оруулалтын төсөвт тусгагдаагүй, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр авто тээврийн хэрэгсэл худалдан авахаар 169,570,060.59/Нэг зуун жаран есөн сая таван зуун далан мянга жаран төгрөг тавин есөн мөнгө/-ийн урьдчилгаа төлбөр төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 16 дугаар зүйлийн 16.5.5-т батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; 42 дугаар зүйлийн 41.2.2-т батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах; Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 1.2-т "Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, акталж данснаас хасах, шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан *"Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"*-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсөвт тусгагдаагүй хөрөнгө оруулалтын ажлыг санхүүжүүлж буй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга (Л.Мөнхтүшиг), Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Отгонцэцэг) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | Э.ЭНХБААТАР |
| АУДИТОР | С.АЛТАНХУЯГ |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-18.Docx

1526181400

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 25 өдөр Дугаар 1138/А0171076 Улаанбаатар хот

САГ-2026/6/ИА-СТА-ТТ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дипломат төлөөлөгчийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дипломат төлөөлөгчийн газарт олон жилийн насжилттай болон тооцоо нийлээгүй дараах авлага бүртгэлтэй байна. Үүнд:

- Гадаадын иргэн, харьяатын газраас авах визийн наадаг хуудасны төлбөр болох 2021 онд үүссэн 39,871,577.98/Гучин есөн сая найман зуун далан нэгэн мянга таван зуун далан долоон төгрөг ерэн найман мөнгө/-ийн авлага бүртгэлтэй боловч тооцоо нийлсэн актгүй;
- Дипломат төлөөлөгчийн газрын ажиллагсдын Хувь хүний орлогын албан татварын төлөлтийг 2024 онд 14,665,009.43/Арван дөрвөн сая зургаан зуун жаран таван мянга есөн төгрөг дөчин гурван мөнгө/-өөр илүү, 2025 онд 8,857,545.81/Найман сая найман зуун тавин долоон мянга таван зуун дөчин таван төгрөг наян нэгэн мөнгө/-өөр тус тус илүү төлж авлага үүсгэсэн, харьяа дүүргийн татварын албатай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан *"Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"*-ын 4.2.1.1-д *"Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй"* гэж заасны үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Олон жилийн насжилттай авлагыг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга (Л.Мөнхтүшиг), Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Отгонцэцэг) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | Э.ЭНХБААТАР |
| АУДИТОР | С.АЛТАНХУЯГ |

9004199
АТА16087
9025081411

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 25 өдөр Дугаар 1139/А0171076 Улаанбаатар хот

САГ-2026/6/НА-СТА-ТТ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дипломат төлөөлөгчийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дипломат төлөөлөгчийн газруудын санхүүгийн тайлангийн нэгтгэл хийхэд Аксплорер ХХК-ны Таст санхүүгийн программыг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд тус программ хангамж нь "Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамжийн жагсаалтад бүртгэлгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.11-д "Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн програм хангамжийг нийтэд мэдээлэх", Сангийн сайдын 2022 оны 09 сарын 30-ний өдрийн 197 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт "Аж ахуй нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага"-ын 1.2-т "Тооцооны аргачлал нь олон улсын стандартад заагдсан бүх аргыг хэрэглэх боломжтой байх", 1.10-т "Санхүүгийн тайлангийн аудит хийхэд хялбар дөхөмтэй, мэдээллийн эх үүсвэр иж бүрнээр/ анхан шатны баримтын мэдээлэл, дансанд бичилт хийсэн мэдээлэл/ тодорхой харуулдаг байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтлөж, баталгаажуулаагүй"гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамж ашиглаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга (Л.Мөнхтүшиг), Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Отгонцэцэг) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Э.ЭНХБААТАР
АУДИТОР С.АЛТАНХУЯГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

*Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-18.Docx*

1526181404